



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/76

Хархорин сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1.1 дэх заалт, Монгол улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн "Дархлаажуулалтын үндэсний товлотыг шинэчлэн батлах тухай" 472 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн "Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах тухай" А/455 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын хамтарсан 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн "Боловсролын сургалтын байгууллагад суурилсан дархлаажуулах үйл ажиллагааг зохион байгуулах тухай" А/484, А/231 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1.Хүний папиллома вирусийн халдварын эсрэг дархлаажуулалтыг эрчимжүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
- 2.Хүний папиллома вирусийн халдварын эсрэг дархлаажуулалтыг эрчимжүүлэх аймгийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, үр дүнг тооцон ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Засаг даргын Тамгын дарга (Х.Лхагвадулам)-д даалгасугай.
- 3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Д.Батчулуун)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.БАТ-ЭРДЭНЭ

